

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛДҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд үнэт цаасны зохицуулалттай зах зээлд үнэт цаас зээлдүүлэхтэй холбогдон үүсэх ерөнхий харилцааг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд үнэт цаас зээлдүүлэхтэй холбогдон үүсэх нарийвчилсан харилцааг энэ журмын хүрээнд мэргэжлийн байгууллагаас баталсан дүрэм журам эсвэл оролцогч талуудын хооронд байгуулах гэрээгээр зохицуулна.
- 1.3 Энэхүү журамд Хорооны шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулна.

Хоёр. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 “Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа” гэж үнэт цаасыг өмчлөгч этгээд энэхүү журамд заасан ерөнхий нөхцөлийг хүлээн зөвшөөрч өмчлөлийн үнэт цаасаа бусад этгээдэд тодорхой нөхцөлийн дагуу зээлдүүлэх, зээлийн хугацаа дуусахад зээлдэгч тухайн үнэт цаасыг нэр төрөл, тоо ширхгээр зээлийн хүүгийн хамт зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх харилцааг ойлгоно.
- 2.2 Хороо нь бүртгэлтэй үнэт цаасны ангилал, ханшийн хэлбэлзэл, хөрвөх чадвараас хамааруулан зээлдүүлэхийг зөвшөөрсөн үнэт цаасны жагсаалт батална.
- 2.3 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд дараах этгээдүүд оролцоно. Үүнд:
 - 2.3.1 Зуучлагч;
 - 2.3.2 Үнэт цаас зээлдүүлэгч;
 - 2.3.3 Үнэт цаас зээлдэгч;
- 2.4 Үнэт цаасны зах зээл дээр кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эсвэл үнэт цаасны номинал данс эзэмших эрхийг Хорооноос авсан, үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд зуучлах сонирхолтой хуулийн этгээдийг Зуучлагч гэнэ.
- 2.5 Зуучлагчаар дамжуулан өөрийн эзэмшлийн үнэт цаасаа зээлдүүлэх хүсэлтээ илэрхийлж тодорхой нөхцөл бүхий гэрээ байгуулсан иргэн хуулийн этгээдийг Үнэт цаас зээлдүүлэгч гэнэ.
- 2.6 Зуучлагчаар дамжуулан үнэт цаас зээлдэх хүсэлтээ илэрхийлж тодорхой нөхцөл бүхий гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг Үнэт цаас зээлдэгч гэнэ.
- 2.7 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаа дараах байдлаар хэрэгжинэ. Үүнд:
 - 2.7.1 Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон үнэт цаасны номинал данс эзэмших эрх Хорооноос авсан мэргэжлийн байгууллагын Гүйцэтгэх удирдлага үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд зуучлагчаар оролцох тухай шийдвэр гарган энэ тухай Хороонд мэдэгдэнэ.

- 2.7.2 Үнэт цаас зээлдүүлэгчийн хүсэлтийн дагуу Зуучлагч Үнэт цаас зээлдүүлэгчтэй “Үнэт цаасны зээлийн зуучлалын гэрээ” байгуулж, зээлдүүлэх үнэт цаасыг өөрийн номинал дансанд Үнэт цаас зээлдүүлэгчийн нэр дээр бүртгэнэ.
- 2.7.3 Зуучлагч зээлдүүлэх боломжтой үнэт цаасны тоо ширхгийг үнэт цаас бүрээр өөрийн цахим хуудсанд оруулна.
- 2.7.4 Үнэт цаас зээлдэгч үнэт цаас зээлдэх хүсэлтийг Зуучлагчид гаргах бөгөөд Зуучлагч тухайн харилцагчийг таньж мэдсэний үндсэн дээр үнэт цаас зээлдүүлэх эсэх шийдвэр гаргана.
- 2.7.5 Үнэт цаас зээлдэх хүсэлт гаргасан этгээдэд үнэт цаас зээлдүүлэх боломжтой гэж Зуучлагч үзсэн тохиолдолд Үнэт цаас зээлдэгчтэй “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ” байгуулна.
- 2.7.6 “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ”-г байгуулахдаа Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны гаргасан “Үнэт цаас зээлдүүлэх мастер гэрээ”-ний үндсэн зарчмуудыг мөрдөнө.
- 2.7.7 Үнэт цаас зээлдүүлэх гэрээнд дараах асуудлыг заавал тусгана. Үүнд:
- i) Зээлдүүлэх үнэт цаасны тоо хэмжээ, нэг бүрийн болон нийт үнийн дүн;
 - ii) Зээлийн хүүгийн хувь хэмжээ;
 - iii) Зээлийн хугацаа;
 - iv) Зээлийн барьцаа;
 - v) Зээлийн барьцааны үнэлгээ;
 - vi) Талуудын эрх үүрэг;
- 2.7.8 “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ” байгуулсны дараа Зээлдэгчийн хүсэлтээр Зуучлагч зээлдүүлсэн үнэт цаасыг Зуучлагчийн номинал данс дахь Үнэт цаас зээлдүүлэгчийн нэрийн данснаас Үнэт цаас зээлдэгчийн нэрийн дансанд шилжүүлнэ.
- 2.7.9 Зээлдүүлсэн үнэт цаасыг захиран зарцуулах эрх гэрээний хугацаанд Үнэт цаас зээлдэгчид бүрэн шилжинэ.
- 2.7.10 Үнэт цаас зээлдүүлэх гэрээний хугацаа дуусахаас өмнө Үнэт цаас зээлдэгч нь зээлсэн үнэт цаасыг нэр төрөл, тоо ширхгээр Зуучлагчийн үнэт цаасны номинал дансанд, зээлийн хүүг Зуучлагчийн дансанд байршуулах үүрэгтэй бөгөөд гэрээний хугацаа дууссан өдөр Зуучлагч үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал данс дахь зээлдүүлсэн үнэт цаас болон зээлийн хүүг Үнэт цаас зээлдүүлэгчийн нэр дээр буцаан бүртгэнэ.
- 2.7.11 Зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг, үнэт цаасны хүү зэрэг үнэт цаасны эзэмшилтэй холбоотой бүх төрлийн өгөөж хүртэх эрх Үнэт цаас зээлдүүлэгчид хадгалагдах ба Үнэт цаас зээлдэгч нь тухайн төлбөрийг хүлээн авсан даруй Зуучлагчаар дамжуулан Үнэт цаас зээлдүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй.
- 2.7.12 Үнэт цаас зээлдүүлэгч нь үнэт цаасаа хэдийд ч буцаан дуудах эрхтэй байх бөгөөд энэ тухай Үнэт цаас зээлдүүлэх гэрээнд тусган Зуучлагч тухайн үнэт цаасыг зах зээл дээрээс олж Үнэт цаас зээлдүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй.
- 2.8 Үнэт цаас зээлдүүлэгч болон Үнэт цаас зээлдэгч үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан үйлчилгээний хөлсийг Зуучлагчид төлнө.
- 2.9 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанаас олсон Үнэт цаас зээлдүүлэгчийн орлогын татварын тайлан гаргах, татвар төлөх үйл ажиллагааг Үнэт цаас зээлдүүлэгч болон Зуучлагчийн хооронд байгуулсан “Үнэт цаас зээлдүүлэх зуучлалын гэрээ”-гээр зохицуулна.

Гурав. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 3.1 “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ”-тэй холбоотой үүсч болзошгүй эрсдэлийг Зуучлагч хариуцан удирдана.
- 3.2 Үнэт цаас зээлдэх хүсэлт гаргасан этгээдтэй “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ” байгуулахаас өмнө Зуучлагч үнэт цаас зээлэхтэй холбогдон үүсч болзошгүй эрсдэлийн тухай мэдээллийг Үнэт цаас зээлдэгчид танилцуулсан байна.
- 3.3 Зуучлагч үнэт цаасны зээлийн бүртгэлийг Үнэт цаас зээлдэгч тус бүрээр хөтөлнө.
- 3.4 Зуучлагч барьцааны хөрөнгийг мөнгө эсвэл үнэт цаас хэлбэрээр өөрийн нэрийн дансанд шилжүүлэн бүртгэнэ.
- 3.5 Зуучлагч зээлдүүлсэн үнэт цаас болон барьцааны үнэт цаасны ханшнаас хамааруулан барьцааны үнэлгээг арилжааны өдөр бүр шинэчлэн гаргана.
- 3.6 Барьцааны үнэлгээ тогтоосон хэмжээнээс буурсан тохиолдолд Зуучлагч барьцаа хөрөнгийг тухайн өдөрт багтаан нэмэгдүүлэхийг Үнэт цаас зээлдэгчээс шаардана.
- 3.7 Барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх тухай Зуучлагчийн гаргасан шаардлагыг Үнэт цаас зээлдэгч хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд зуучлагч “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ”-нд заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.8 “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ”-нд заасан тохиолдолд зээлдүүлсэн үнэт цаасыг худалдсан орлогод хамаарах мөнгөн хөрөнгийг барьцаанд тооцож болно.
- 3.9 Зах зээлд үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох болон зээлсэн үнэт цаасыг зарах үнийн доод хязгаарыг тогтоох арга хэмжээг хэрэгжүүлж болно.

Дөрөв. ОЛОН НИЙТЭД БОЛОН ХОРООНД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

- 4.1 Дараах мэдээллийг Хороонд хүргүүлнэ. Үүнд:
 - 4.1.1 Зээлдүүлэхийг зөвшөөрсөн үнэт цаасны жагсаалтыг уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр;
 - 4.1.2 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 5-ны дотор;
 - 4.1.3 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох, зээлсэн үнэт цаасыг зарах үнийн доод хязгаарыг тогтоох тухай бүр;
- 4.2 Зуучлагч дараах мэдээллийг Хороонд хүргүүлнэ. Үүнд:
 - 4.2.1 Үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаатай холбоотой зуучлалын үйлчилгээний хөлс өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр;
 - 4.2.2 Үнэт цаас зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;
 - 4.2.3 Үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр;

* * * * *